



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮАГ-НАГ-2019/01/-НА



ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДАС ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН
БАЙРШУУЛАЛТ 96,5 ХУВЬТАЙ БАЙНА.

Чойбалсан хот
2019 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь
Төрийн аудитын газрын

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Нийцлийн аудитын
албаны Аудитор
Б.Батжаргал,
Б.Одхүү
Г.Хонгорзул
Утас: 70584207

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал 7058-
4204, 7058-4207 дугаарын
утас болон
www.dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
АЗДТГ-ын 2-р байр,
1 давхар 02 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга

БҮЛЭГ I. Шилэн дансны цахим хууд мэдээллийн байршуулалт 96,5 хувьтай

1.1 Шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийн байршуулалт 96,5 хувьтай байна.

1.2 Шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлага дагуу бүрэн мэдээлээгүй байна.

БҮЛЭГ II. Төрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний дээр гүйцэтгэгч байгууллагууд нь хуудсанд цэсээ бүрэн нээлгээгүй байгаа

2.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар
3.1.3-т заасан байгууллага цахим
орлуулах мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр
орлуулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ
үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн
байгууллагуудын мэдээлэл аймгийн ЗДТГ-аас
дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй
байна.

2.3 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ
хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр
байгууллагууд нь цахим хуудсанд цэсээ
нээлгээгүй байна.

БҮЛЭГ III. Шилэн дансны тухай хууль холбогдох байгууллага, албан тушаал хяналтыг хэрэгжүүлж ажилласан мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн нийтлэг зөрчил гарсаар байна.

3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэлт
хяналт тавьж ажилласан байна.

3.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг
хэрэгжүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ААН	Аж ахуй нэгж
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг удирдамж болгон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт заасан 200 хуулийн этгээд, төрийн байгууллага, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэхийг шалгалаа.

Үндсэн мэдээлэл:

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.

Өмнөх оны аудитаар Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн системд хамрагдвал зохих нийт байгууллагын 98,2 хувь хамрагдсан гэж дүгнэсэн байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Нийцлийн аудитын стандарт (АДБОУС 4000), гарын авлага, журам, удирдамжид заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, ажиглалт хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

Хууль

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам /2016 оны №29/
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам /2017 оны №89/

Холбогдох бусад хууль эрх зүйн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж нийцлийн аудитын албаны аудитор Б.Батжаргал, Б.Одхүү, Г.Хонгорзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 01-ны өдөр эхэлж 04 дүгээр сарын 05-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж УАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажууллаа.

БҮЛЭГ I. Шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийн байршуулалт 96,5 хувьтай байна.

1.1. Шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийн байршуулалт 96,5 хувьтай байна.

Дорнод аймгийн хэмжээнд шилэн дансны цахим мэдээллийн санд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болох орон нутгийн төсвийн 128, улсын төсвийн 43 байгууллага, орон нутгийн өмчит газар 28, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 3 байна. Үүнээс Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил, Баяндун сумын Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ууд нь цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд хамрагдсан байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хэрэгжилтийг шалгахад:

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан

- Тухайн жилийн төсвийг мэдээлбэл зохих 200 байгууллага 99,0 хувьтай мэдээлсэн байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг, мэдээлбэл зохих 200 байгууллага 92,5 хувьтай мэдээлсэн байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг, мэдээлбэл зохих 15 байгууллага 100 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан

- Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 200 байгууллага 98,5 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасан

- Жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлбэл зохих дараа жилийн төсвийн төслийг 200 байгууллага 75,5 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан

- Жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлбэл зохих хагас жилийн тайланг 200 байгууллага 89,5 хувьтай мэдээлсэн байна.
- Дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлбэл зохих жилийн эцсийн санхүүгийн тайланг 200 байгууллага 98,5 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан

- Тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн эхээр нь мэдээлбэл зохих төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг 200 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.
- Тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлбэл зохих аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 200 байгууллага 82,0 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан

- Улирал бүр мэдээлбэл зохих төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 200 байгууллага 68,5 хувьтай мэдээлсэн байна.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийг 95,0 хувь нь мэдээлсэн байна.

Өмнөх онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийг 97,0 хувьтай мэдээлж байсан ч тайлант онд 2,0 хувиар буурсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээллийг мэдээлэх хувь буурсан шалтгаан нь төсвийн байгууллагууд дараа жилийн төсвийн төсөл 75,5 хувь, хагас жилийн санхүүгийн тайлан 89,5 хувь, аудитын зөвлөмж аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 82,0 хувь, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар 68,5 хувьтай мэдээлсэн нь нөлөөлсөн байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хяналт шалгалтын дүн, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтын хэрэгжилтийг шалгахад:

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтын дагуу тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээлбэл зохих 200 байгууллага 85,6 хувьтай мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 дахь заалтын дагуу тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлбэл зохих 200 байгууллага 96,0 хувьтай мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь заалтын дагуу тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 200 байгууллага 97,5 хувь мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтын дагуу таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын нийт 12848,0 сая төгрөгийн 569 гүйлгээний мэдээллийг, мэдээлбэл зохих 200 байгууллага байгууллага 99,5 хувьтай мэдээлсэн байна. 189,8 сая төгрөгийн 14 мэдээллийг 3 байгууллага мэдээлээгүй байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтын дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээлбэл зохих 53576,0 сая төгрөгийн 754 гүйлгээнээс 387,9 сая төгрөгийн 34 гүйлгээг 21 байгууллага мэдээлээгүй байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлбэл зохих 25327,0 сая төгрөгийн 359 гүйлгээнээс 279,7 сая төгрөгийн 16 гүйлгээг 10 байгууллага мэдээлээгүй байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6-д зааснаар худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаар 200 байгууллага 97,5 хувь мэдээлэл оруулсан байгаа ч тайлант хугацаанд шалгалт хийгдээгүй гэсэн тайлбар бичсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагч болон 2018 онд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийгдсэн төсөвт байгууллагуудын мэдээллийг шалгахад хяналт, шалгалтын талаар үнэн зөв мэдээлээгүй, аудитын дүнг оруулаагүй байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дахь заалтын дагуу байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 200 байгууллага 99,5 хувь мэдээлсэн байна.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 200 байгууллага 99,5 хувь мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг 98,0 хувь нь мэдээлсэн байна.

1.2. Шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлээгүй байна.

Нийцлийн аудитаар аймгийн төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан эсэхийг Шилэн дансны тухай хуулийн 5.7 дахь “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.” гэсэн заалтын дагуу хэрэгжилтийг газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1

№	Сумдын нэр	Шилэн дансны хуулийн заалт	Гүйцэтгэлийн хувь заалт бүрээр	Гүйцэтгэлийн хувь
1	Баяндун	6.1.1	60	46
		6.1.2	54	
		6.1.3	50	
		6.1.4	25	
		6.1.5	89	
		6.1.6	0	
2	Баянтүмэн	6.1.1	58	32
		6.1.2	54	
		6.1.3	29	
		6.1.4	23	
		6.1.5	29	
		6.1.6	0	
3	Баян-Уул	6.1.1	60	53.5
		6.1.2	56	
		6.1.3	67	
		6.1.4	45	
		6.1.5	93	
		6.1.6	0	
4	Булган	6.1.1	92.3	74.5
		6.1.2	92.3	
		6.1.3	87.5	
		6.1.4	87.5	
		6.1.5	87.5	
		6.1.6	0	
5	Гурванзагал	6.1.1	0.08	2.4
		6.1.2	0	
		6.1.3	0	

		6.1.4	0	
		6.1.5	14	
		6.1.6	0	
6	Дашбалбар	6.1.1	63.6	39.5
		6.1.2	30.7	
		6.1.3	14.3	
		6.1.4	71.4	
		6.1.5	57.1	
		6.1.6	0	
7	Матад	6.1.1	100	75.0
		6.1.2	50	
		6.1.3	100	
		6.1.4	100	
		6.1.5	100	
		6.1.6	0	
8	Сэргэлэн	6.1.1	100	66.6
		6.1.2	100	
		6.1.3	0	
		6.1.4	100	
		6.1.5	100	
		6.1.6	0	
9	Халхгол	6.1.1	66.6	64.6
		6.1.2	92.3	
		6.1.3	85.7	
		6.1.4	57.1	
		6.1.5	85.7	
		6.1.6	0	
10	Хөлөнбуйр	6.1.1	83.3	62.4
		6.1.2	76.9	
		6.1.3	71.4	
		6.1.4	71.4	
		6.1.5	71.4	
		6.1.6	0	
11	Хэрлэн	6.1.1	100	89.5
		6.1.2	83	
		6.1.3	100	
		6.1.4	87	
		6.1.5	100	
		6.1.6	67	
12	Цагаан-овоо	6.1.1	83.3	70.8
		6.1.2	84.6	
		6.1.3	85.7	
		6.1.4	85.7	
		6.1.5	85.7	
		6.1.6	0	
13	Чойбалсан	6.1.1	41.6	20.5
		6.1.2	33.3	
		6.1.3	0	

		6.1.4	37.5	
		6.1.5	11.1	
		6.1.6	0	
14	Чулуунхороот	6.1.1	66.6	37.8
		6.1.2	33.3	
		6.1.3	0	
		6.1.4	55.5	
		6.1.5	71.4	
		6.1.6	0	
	Дүн /дундаж/			52.5

Аймгийн хэмжээний нийт төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээллийн мэдээллийн самбар дахь байршуулалт 52,5 хувьтай байна.

БҮЛЭГ II. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд нь цахим хуудсанд цэсээ бүрэн нээлгээгүй байна.

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага цахим хуудсанд оруулах мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани гэсэн хуулийн заалтад хамаарах “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6.8 дахь заалтын дагуу шилэн дансны цахим хуудсанд 7 төрлийн мэдээллийг мэдээлэхээр байна.

- Хуулийн 3.2.5-д зааснаар “Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, шийдвэрийн талаарх мэдээлэл”-ийг нийт 121 тушаал, шийдвэрийн 2127,3 сая төгрөгийг мэдээлэхээс 1167,1 сая төгрөгийн 13 шийдвэрийг мэдээлээгүй байна.
- 3.2.7-д заасан Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концессын талаарх мэдээлэл, 3.2.8-д заасан Засгийн газрын орон нутгийн баталгаа, Төрийн байгууллага, улсын төсөвтэй холбоотой үүссэн өр, авлагын талаарх мэдээлэл, 6.8.3-т заасан Их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа батлан даалтын шийдвэрийн талаар тайлант хугацаанд гүйлгээ гараагүй байна.
- Хуулийн 6.10 дугаар зүйлд зааснаар Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна гэсэн заалтын дагуу эрх бүхий 22 хүний мэдээллээс 2 албан тушаалтан мэдээллээ оруулаагүй байна.

2.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл аймгийн ЗДТГ шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлэгдсэн байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад хамаарах байгууллагууд нь 6

дугаар зүйлийн 6.9 дэх¹ заалтыг хэрэгжүүлж, улс, орон нутаг болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар олгосон 60 төсөл, арга хэмжээний 3579,4 сая төгрөгийн санхүүжилтийг захиалагч болох АЗДТГ-ын шилэн дансны цахим мэдээлэлд бүрэн мэдээлсэн байна. /Хавсралт маягт 4/ Харин гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд нь Шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэж, мэдээллээ байршуулаагүй байна.

2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд нь цахим хуудсанд цэсээ бүрэн нээлгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага”-д хамаарах нийт 14 байгууллага шилэн дансанд хамрагдахаас 10 байгууллага хамрагдсан байна.

“Түгээмэл оюу” сургууль, “Саруул ирээдүй”, “Нарлаг ордон”, “Зугаатай ордон” цэцэрлэгүүд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй, нийт 146,7 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй байна. /Хавсралт маягт 5/

БҮЛЭГ III. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч мэдээллийг хугацаа хоцроон мэдээлдэг нийтлэг зөрчил гарсаар байна.

3.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал ... хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Аймгийн ИТХ нь 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тусгасан байна.

Төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг сонсож, шилэн дансны нэгдсэн системд мэдээ тайлангаа хуулийн хугацаанд тайлагнаагүй буюу хугацаа хоцроон тайлагнасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох тухай үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албанаас Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн хамрах хүрээний 146 байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд улирал бүр дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 дүгээр улирлын байдлаар 98,5 хувиар дүгнэсэн байна.

¹ “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр ... төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, харажилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ... санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй”

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2018 онд хяналт шалгалтыг 4 удаа хийн аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаан, орон нутгийн байгууллагуудын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнуудад мэдээлж, хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээг Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Сангийн Яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт улирал бүр хүргүүлжээ.

Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сүүлийн жилүүдэд 96 - 99 хувьтай байгаа нь дотоод хяналтыг хуулийн дагуу тогтмол хийж байгаатай холбоотой байна.

3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны аудитаар дараах зөвлөмжүүдийг холбогдох албан тушаалтанд өгсөн байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад өгсөн “Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах” гэсэн зөвлөмжийн дагуу хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргад өгсөн “Шилэн дансны тухай хуулийн 3.1.3 дахь заалтын дагуу Шилэн дансны мэдээллийн санд цэсгүй байгууллагуудад мэдээлэл байршуулах цэс нээлгэх.” гэсэн зөвлөмжийн дагуу цэс нээлгээгүй орон нутгийн төсвийн байгууллагын цэсийг нээлгэсэн байна. Мөн “Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4 дэх заалтад заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлэхэд анхаарч ажиллах.” гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийн байршуулалт 96,5 хувьтай байна.
2. Шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлээгүй байна.
3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага цахим хуудсанд оруулах мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.
4. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд нь цахим хуудсанд цэсээ бүрэн нээлгээгүй байна.
5. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч мэдээллийг хугацаа хоцроон мэдээлдэг нийтлэг зөрчил гарсаар байна.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2019.04.08 № 4679

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Уг тайланд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны бус байгууллага болох "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн мэдээллийг тусгасан нь хуулийн хэрэгжилтийн нийт хувийг бууруулсан байна.

Цаашид төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудад аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН



010619202

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг даргад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн мэдээлж ажиллах,
2. Байгууллагын мэдээллийн самбарт Шилэн дансны тухай хуулийн 5.7 дахь заалтын дагуу бүрэн мэдээлж байх,
3. Аудитын дүнг сумдын Засаг дарга, аймгийн харьяа агентлагуудын удирдлагуудад танилцуулж ажиллах,

Аудитаар нийт 2171,2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн зөрчил арилгуулах 1313,8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 санал хүргүүлж, 857,4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар бичигдсэн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 07 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 13

Чайвасгийн хөт

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Энхбаатар, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор /Б.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

110219022

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2019 оны
04 дүгээр сарын 10-ны өдрийн
1/2 дугаар тушаалын хавсралт

Акт, албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлага	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	ДБЭХС ТӨХК	ҮАГ-НАГ-2019/01/-НА	01/111	1167.1
Дүн				1167.1